



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 07 дугаар сарын 15 өдөр Дугаар 67

Хэрлэн сум

LXVI ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 67 дугаар хуралдаан 2021 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 13:00 цагт цахимаар 86,5 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1. Улсын Онцгой комиссын шийдвэрээр хот хоорондын хөдөлгөөнийг нээсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал танилцуулах,  
*Эрүүл мэндийн газар*

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

1.1. Халхгол, Баян-Уул сумдад аялал, зугаалах зорилгоор зорчиж ирсэн иргэдийг 7 хоног гэрийн тусгаарлалтад авах тухай аймгийн Онцгой комиссын тогтоол гаргах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,  
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн цагдаагийн хурандаа Т.Ганзориг нарт:

1.2. Буйр нууранд иргэд ихээр амарч байгаатай холбогдуулан Хэрлэн сумын 5 дугаар багийн нутаг "Өлзийт" хорооллын Халхгол сум чиглэлийн замд шалган нэвтрүүлэх хяналтын цэгийг нэмэлтээр гаргах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,  
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа нарт:

1.3. Буйр нууранд иргэд ихээр амарч байгаатай холбогдуулан Хэрлэн сумын 5 дугаар багийн нутаг "Өлзийт" хороололд шатахууны түгээх цэгийг нэмэлтээр гаргаж ажиллуулах,

/ 

/ М.Бадамсүрэн

/ Хур Г.Нармандах

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа-д:

1.4.Буйр нууранд иргэд ихээр амарч байгаатай холбогдуулан Хэрлэн сумын 5 дугаар багийн нутаг "Өлзийт" хороололд зөөврийн эмийн санг томилж ажиллуулах,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Д.Мөнхтуяа-д:

1.5.Буйр нууранд иргэд ихээр амарч байгаатай холбогдуулан Хэрлэн сумын 5 дугаар багийн нутаг "Өлзийт" хороололд дугуй засварын газрыг нэмэлтээр гаргаж ажиллуулах,

Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ж.Алимаа-д:

1.6.Буйр нууранд иргэд ихээр амарч байгаатай холбогдуулан Хэрлэн сумын 5 дугаар багийн нутаг "Өлзийт" хороололд зоогийн газрыг нэмэлтээр ажиллуулах,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн  
цагдаагийн хурандаа Т.Ганзориг-д:

1.7.Ялалт, Модон, Баянтүмэн гүүрний хяналтын цэгт олон нийтийн цагдааг ажиллуулахад гарсан зардлыг тооцож аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэх,

1.8.Тусгаарлах байр, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Халдвартын тасгийн хамгаалалтад ажиллаж буй Цагдаагийн албан хаагч нарын шатахууны зардлыг тооцож аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэх,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын  
орлогч дарга, хурандаа Г.Нармандах,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Д.Мөнхтуяа нарт:

1.9.Ховд аймгаас Дорнод аймаг хүртэл гүйж буй Зэвсэгт хүчний байгууллагын албан хаагч, ахлах ахлагч Э.Даваажамцийг хүлээн авах үйл ажиллагаанд халдвар хамгааллын дэглэмийг баримталж зохион байгуулах,

АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,  
Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ-д:

1.10.Сумдын Онцгой комиссын бүрэлдэхүүнтэй 2021 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 13:00 цагт цахим хурлыг зохион байгуулж аймгийн Онцгой комиссын хуралдааны шийдвэрүүдийг танилцуулж үүрэг чиглэл өгч ажиллахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ  
КОМИССЫН ДАРГА М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ОРЛОГЧ  
ДАРГА, ХУРАНДАА Г.НАРМАНДАХ

